

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/05/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот

2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: В.Жавзмаа

Утас: 70357955 Цахим хаяг: [javzmaav@audit.gov.mn](mailto:javzmaav@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.04.01 № 96

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.НАРМАНДАХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд шимтгэл төлөгч 1,469 аж ахуйн нэгжийн 30,614 албан журмын даатгуулагч, сайн дурын 5,014 даатгуулагчаас нийгмийн даатгалын санд 183,421.9 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 96.37 хувьтай биелүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын багц хууль 2024 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сангуудыг төсвийг НДЕГ-аас хуваарилдаг болж, шинэ цахим систем нэвтрүүлснээр мэдээллүүд нэгтгэхэд алдаа гарч, сангийн санхүүгийн тайлан Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааг хоцруулж, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн.

### **Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА



**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,774,408,552.98	24,513,349,502.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,279,552,356.43	15,568,923,107.65
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	17,279,552,356.43	15,568,923,107.65
31210	Төгрөг	17,279,552,356.43	15,568,923,107.65
31211	Төрийн сангийн харилцах	246,638,028.51	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	17,032,914,327.92	15,568,923,107.65
33	АВЛАГА	9,494,856,196.55	8,944,426,394.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,581,525,478.08	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,875,560,504.41	3,853,721,777.41
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	5,020,164,932.03
33500	Бусад авлага	37,770,214.06	70,539,685.06
33510	Байгууллагаас авах авлага	37,770,214.06	33,827,215.13
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	36,712,469.93
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,774,408,552.98	24,513,349,502.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,853,152,627.87	3,725,737,661.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,853,152,627.87	3,725,737,661.76
41300	Өглөг	108,934,020.31	2,342,556,212.39
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	108,934,020.31	0.00
41360	Бусад өглөг	0.00	2,342,556,212.39
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	97,156,373.87
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2,245,399,838.52
41400	Урьдчилж орсон орлого	1,744,218,607.56	1,383,181,449.37
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,744,218,607.56	1,383,181,449.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,921,255,925.11	20,787,611,840.39
51	Засгийн газрын хувь оролцоо	24,921,255,925.11	20,787,611,840.39
51200	Хуримтлагдсан үр дүн	24,921,255,925.11	20,787,611,840.39
51210	Өмнөх үеийн үр дүн	28,479,631,221.04	24,180,904,236.29
51220	Тайлант үеийн үр дүн	-3,558,375,295.93	-3,393,292,395.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,774,408,552.98	24,513,349,502.15

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	202,430,986,354.35	385,494,963,048.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	169,895,444,657.94	173,238,285,802.92
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	169,895,444,657.94	173,238,285,802.92
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	113,108,687,853.07	140,168,332,270.81
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	11,989,379,491.29	14,886,175,070.27
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	15,899,389,979.16	12,679,471,226.26
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,456,985,193.14	5,504,307,235.58
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	26,441,002,141.28	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	186,408,699.41	124,646,339.22
120	Нийтлэг татварын бус орлого	186,408,699.41	124,646,339.22
120002	Хүүгийн орлого	99,004,068.57	103,048,121.61
120003	Торгуулийн орлого	0.00	9,799,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,755,233.84	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,755,233.84	0.00
120009	Бусад орлого	30,649,397.00	11,798,717.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,349,132,997.00	212,132,030,906.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	17,021,748,532.00	35,081,699,356.56
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,021,748,532.00	35,081,699,356.56
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	205,989,361,650.28	388,888,255,444.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,989,361,650.28	388,888,255,444.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,032,570.00	15,925,311.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,032,570.00	15,925,311.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,688,001.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,032,570.00	10,237,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	205,982,329,080.28	388,872,330,133.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	168,926,860,294.00	216,955,771,558.25
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	168,926,860,294.00	216,955,771,558.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,055,468,786.28	171,916,558,575.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,055,468,786.28	171,916,558,575.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-3,558,375,295.93	-3,393,292,395.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,558,375,295.93	-3,393,292,395.90

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	209,864,361,988.08	417,346,590,646.13
11	ТАТВАРЫН ОРЛОГО	170,898,895,370.44	205,451,006,811.93
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	170,898,895,370.44	205,451,006,811.93
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	113,774,044,467.11	138,198,242,646.54
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	12,072,238,081.23	14,623,973,399.75
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	15,979,211,943.52	15,727,098,976.74
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,474,617,711.50	5,651,476,210.08
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	26,598,783,167.08	31,250,215,578.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,750,917,465.00	211,727,699,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	23,423,533,000.00	34,677,367,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	23,423,533,000.00	34,677,367,600.00
1330	Төсвийн захирагчдаас	15,327,384,465.00	177,050,331,550.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,327,384,465.00	177,050,331,550.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,047,745,145.18	419,057,219,894.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,047,745,145.18	419,057,219,894.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,032,570.00	44,842,790.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,032,570.00	15,925,311.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,688,001.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,032,570.00	10,237,310.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	28,917,479.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	28,917,479.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	206,040,712,575.18	419,012,377,103.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	168,985,243,788.90	214,835,346,896.43
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	168,826,382,567.10	214,835,346,896.43
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,055,468,786.28	204,177,030,207.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,055,468,786.28	204,177,030,207.55
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,816,616,842.90	-1,710,629,248.78
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,816,616,842.90	-1,710,629,248.78
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,462,935,513.53	17,279,552,356.43

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,279,552,356.43	15,568,923,107.65
----	---	-------------------	-------------------

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	28,481,308,507.42	28,481,308,507.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,677,286.38	-1,677,286.38
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,479,631,221.04	28,479,631,221.04
9	Тайлант үеийн үр дүн	-3,558,375,295.93	-3,558,375,295.93
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,921,255,925.11	24,921,255,925.11
11	2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	24,921,255,925.11	24,921,255,925.11
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-740,351,688.82	-740,351,688.82
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,180,904,236.29	24,180,904,236.29
19	Тайлант үеийн үр дүн	-3,393,292,395.90	-3,393,292,395.90
20	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	20,787,611,840.39	20,787,611,840.39

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,477,617,200.00	214,851,272,207.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,477,617,200.00	214,851,272,207.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,222,200.00	15,925,311.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,222,200.00	15,925,311.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,903,300.00	5,688,001.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,318,900.00	10,237,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	218,457,395,000.00	214,835,346,896.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	218,457,395,000.00	214,835,346,896.43
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	218,457,395,000.00	214,835,346,896.43
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,477,617,200.00	208,978,960,499.23
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,677,367,600.00	34,677,367,600.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	34,677,367,600.00	34,677,367,600.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	183,800,249,600.00	174,301,592,899.23
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	183,800,249,600.00	174,301,592,899.23
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	17,279,552,356.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	15,568,923,107.65

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 739.3 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 739.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй боловч шийдвэргүйгээр 739.3 сая төгрөгийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга бүртгэсэн нь УСНББОУС 1, 28 болон аудитын ангилал, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайлан, тодруулгад залруулав.

Аудитаар нийт 0.4 сая мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 0.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй зөрчилтэй асуудлаас 0.4 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

### **3.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **3.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт 1:**

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамжийн зардлыг 0.4 сая төгрөгөөр бууруулж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж 1:**

Сангийн зардлыг бууруулах бичилт хийхгүй нийт дүнгээр нь үнэн зөв тайлагнаж, сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллах.

#### **2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт 2:**

Сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 15 хоног хугацаа хоцроож ирүүлсэн.

Энэ Төсвийн тухай хуулийн 8.9-д "Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, орон нутгийн төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглаврын дагуу боловсруулна", 8.9.2-т "төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж 2:**

Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд сангийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хариуцлагыг дээшлүүлэх.

**Илрүүлэлт 3:**

Орлогын төлөвлөгөө 7,338.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж 3:**

Сангийн орлогын төлөвлөгөөнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын нөлөөллийг тооцож, орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах.

**3.Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт 4:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх 159 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, төсвийн өөрчлөлтийг дутуу мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"; 7.1-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж 4:**

Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроохгүй байршуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая төгрөг/**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДСан	1	739.3			1	739.3	1	739.3				
Дүн	1	739.3			1	739.3	1	739.3				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
НДСан	3	0.4	-	-	-	-	3	0.4				
Дүн	3	0.4	-	-	-	-	3	0.4				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
НДСан	1							1	
Дүн	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
НДСан									
Дүн									
Нийт дүн	1							1	

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт-тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			